



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.11.07 № 01/165

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
С.САЙНБАЯР ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Цагаандэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар нийт 15,000,000.00 /Арван таван сая/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Халаалтын засварын 15,000,000.00 төгрөгийг барилгын өөрийн өртөгт нэмж капиталжуулаагүй /орлогоор тусд нь бүртгэсэн/ байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.34-т /Үндсэн хөрөнгийн засварын зардал нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах гэх мэт уг хөрөнгөөс хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлж байвал уг зардлыг капиталжуулан үндсэн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлнэ. Бусад тохиолдолд тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө/ заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланд их засварыг бүртгэсэн бичилтийг залруулах.

1000000712


2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Цагаандэлгэр сумын Цагаандэлгэр сумын Засаг даргын тамгын газрын дарга /С.Сайнбаяр/, нягтлан бодогч /Т.Хүдэрчулуун/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ЗӨВШӨӨРСӨН:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР

ДАРГА

С.САЙНБАЯР

НЯГТЛАН БОДОГЧ

Т.ХҮДЭРЧУЛУУН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.